

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ СТРАТЕГИ

2025-2030

БАРИМТ БИЧГИЙН ТАНИЛЦУУЛГА

Энэхүү стратеги нь Аялал Жуулчлалын Мэргэжлийн холбоо (АЖМХ)-ыг урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаатай байлгаж, гишүүддээ шударга, үр дүнтэй үйлчилгээ үзүүлсээр байх, мөн Монгол Улсын аялал жуулчлалын салбарын хөгжлийг дэмжих зорилготой. Уг баримт бичигт байгууллагын бүх үйл ажиллагааг тодорхой, ойлгомжтой зааж өгөх нь нэн чухал бөгөөд ингэснээр Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, салбар холбоод, ажлын алба эсвэл гишүүдэд өөрчлөлт орсон ч байгууллагын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, бодлогын залгамж халаа үргэлжлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Стратеги нь байгууллагын зорилгыг тодорхой, хэмжихүйц байдлаар илэрхийлж, зорилгоо хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө, арга хэмжээг тодорхойлно.

Dulamsuren Batjargal

[Email address]

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО (АЖМХ)-НЫ

СТРАТЕГИ

(2025-2030)

1. БАЙГУУЛЛАГЫН АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС

1.1. АЛСЫН ХАРАА: Монгол Улсыг дэлхийд тэргүүлэх ондоошилтой аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлэхэд салбарын мэргэжлийн байгууллагуудыг нэгтгэн манлайлж, тогтвортой аялал жуулчлалын бодлогыг хэрэгжүүлэх.

1.2. ЭРХЭМ ЗОРИЛГО: Монгол Улсын аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг сайжруулан, салбарын боловсон хүчнийг чадавхижуулан, салбарыг олон улсын түвшинд өрсөлдөхүйц болгож, жуулчдын тоог тогтвортой нэмэгдүүлэн, үндэсний аялал жуулчлалын салбарын хөгжлийг чиглүүлэгч байна.

1.3. ҮНЭТ ЗҮЙЛС:

1.3.1. Мэргэжлийн байдал ба Үр дүнд суурилсан гүйцэтгэл: Мэргэжлийн судалгаа, шинжилгээ, сайн туршлагад тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлэх, олон улсын стандарт нэвтрүүлэн ажиллана. Байгууллагын бүтээмж, гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн, үр дүнг хэмжих боломжтой, хариуцлагатай үйл ажиллагааг төлөвшүүлнэ. Олон улсын стандартын дагуу Монголын аялал жуулчлалын үйлчилгээний чанарыг сайжруулна.

1.3.2. Ёс зүй, Ил тод байдал ба Хариуцлага: Үйл ажиллагаандаа ёс зүйг дээдлэн, соёл уламжлалыг хүндэтгэж, ил тод, хариуцлагатай шийдвэр гаргана. Холбооноос явуулж буй бодлого, шийдвэр гаргалт нээлттэй, олон нийтийн оролцоотой байна.

1.3.3. Тогтвортой хөгжил: Байгаль орчин, соёлын өвийг хамгаалах, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангана.

1.3.4. Нийгмийн хүртээмж ба Хамтын үнэ цэн: Аялал жуулчлалаас үүсэх өгөөжийг бүх хүнд, ялангуяа орон нутаг, иргэдэд хүртээмжтэй болгох зорилготой ажиллана. Салбарын нэгдэл болон дээвэр байгууллага байж орон нутгийн иргэд, хувийн хэвшил, төр, олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллана.

1.3.5. Инноваци ба Цахим шилжилт: Инноваци, цахим шилжилтийг дэмжиж, аялал жуулчлалын үйлчилгээний чанар, хүртээмжийг шинэ шатанд хөгжүүлнэ. Шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлж, шинэ аяллын бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлнэ.

1.4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ:

- 1.4.1. Монголын аялал жуулчлалын салбарын хөгжлийн бодлого, стратегийг тодорхойлоход оролцож, аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, Аялал жуулчлалын асуудал хариуцсан яамтай хамтран төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх,
- 1.4.2. Гишүүн байгууллага, хувь хүмүүст мэргэжлийн хөгжил, бодлогын түвшинд нөлөөлөх боломж, мэдээлэл, туршлага, санхүүжилтийн боломж, нетворк, ёс зүйн зөвлөгөө, эрх ашгийг хамгаалах зэрэг бодит үнэ цэн, дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагааг идэвхжүүлж, салбарын нэгдлийг бэхжүүлэх
- 1.4.3. Монгол Улсын байгаль, түүх, соёлын өв, нөөцийн Монгол хүнээр дамжин гарах үнэ цэн, илэрлийг тодотгосон Монголын аялал жуулчлалыг дэлхийд таниулах урт хугацааны, улирлаас үл хамаарах, ондоошилтой **БРЭНДИЙГ** тодорхойлох, хөгжүүлэх,
- 1.4.4. Аялал жуулчлалын менежментийг сайжруулж, боловсон хүчнийг чадавхижуулах, аялал жуулчлалын үйлчилгээнд олон улсын стандарт нэвтрүүлэх, Аялал жуулчлалын тухай хуулийн 6.5-д заасны дагуу, Засгийн газраас баталсан Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох ажлыг зохион байгуулах, Аялал жуулчлалын тухай хуулийн 10.1-д заасны дагуу, жуулчны хөтөч-тайлбарлагчдад үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох зэрэг үйл ажиллагааг журмын дагуу хэрэгжүүлэх.
- 1.4.5. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх. Эвент, энтертэйнмент, аттракцион, үзмэрүүдийг хөгжүүлж, олон улсын түвшинд өрсөлдөхүйц болгохын тулд стандарт нэвтрүүлж, удирдамж, зөвлөх үйлчилгээгээр хангах.
- 1.4.6. Аялал жуулчлалын улирлын хамаарлыг багасгахыг зорьж, дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, бизнесийн аялал жуулчлал, MICE хөгжүүлэх
- 1.4.7. Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд тогтвортой, үр дүнтэй сурталчлах.
- 1.4.8. Монголчуудын дотоодын аялал жуулчлалын сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор аяллын бүтээгдэхүүний нэр төрлийг өргөжүүлж, хөгжүүлэн сурталчлах.
- 1.4.9. Засгийн газар, төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагууд, хөрөнгө оруулалтын сангууд, бусад салбарын бизнес эрхлэгчидтэй хамтран аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг сайжруулах.
- 1.4.10. Аялал жуулчлалын тухай хуулийн 6.4-д заасны дагуу, тур оператор болон аяллын агентуудын бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологи манлайлан нэвтрүүлж, аялал жуулчлалын салбар дахь цахим шилжилтийг түргэсгэх.

2. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо (АЖМХ) нь Аялал жуулчлалын тухай хуулийн 26.1-д заасан ашгийн төлөө бус, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох хууль ёсны статустай байгууллага юм. Энэхүү хуулийн дагуу АЖМХ нь Монгол Улсын аялал жуулчлалын салбарын хөгжлийг дэмжих, зохицуулах, чанарыг сайжруулах зорилгоор төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх эрх, үүрэгтэй.

Хуулиар АЖМХ-д олгогдсон үндсэн эрх, үүргүүд нь:

- Аялал жуулчлалын байгууллагуудын зохицуулалт: Эрсдэл бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэгчид болон тур оператор, аяллын агентуудыг бүртгэх (Хуулийн 6.3, 6.4, 26.1), мөн аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын ангилал, зэрэглэлийг тогтоох (Хуулийн 6.6, 26.1) эрх мэдлийг хэрэгжүүлнэ.
- Жуулчны хөтөч-тайлбарлагчийн эрх зүйн байдал: АЖМХ нь мэргэжилтэй, эсхүл сургалтад хамрагдсан хөтөч-тайлбарлагчдыг бүртгэж, үнэмлэх олгох (Хуулийн 10.1, 26.1) үүрэгтэй. Түүнчлэн, үнэмлэхийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон тэдний мэргэжлийн ур чадварын зэрэглэлийг тогтоох чиг үүргийг хэрэгжүүлнэ (Хуулийн 10.5, 26.1).
- Маргаан шийдвэрлэх механизм: Жуулчин болон аялал жуулчлалын байгууллагуудын хооронд үүссэн гэрээтэй холбоотой маргааныг АЖМХ-ны дэргэдэх эвлэрүүлэн зуучлагчаар шийдвэрлүүлэх боломжтой (Хуулийн 13.2, 26.1).
- Бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох: Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хэмжээний бодлогын зөвлөлдөх байгууллага болох Үндэсний хорооны бүрэлдэхүүнд АЖМХ-оос санал болгосон таван гишүүн оролцоно (Хуулийн 20.2, 26.1).
- Салбарын чадавхыг дээшлүүлэх, удирдах: Ерөнхийдөө АЖМХ нь тур оператор, аяллын агент, үйлчилгээний байгууллага, хөтөч-тайлбарлагч болон нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчдийн нэгдэл болж, салбарын үйл ажиллагаанд оролцогчдод сургалт, зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах (Хуулийн 26.1, 26.2), мөн салбарын ажилтнуудын мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- Дотоод засаглал ба ил тод байдал: Байгууллагын дүрэм, удирдлага, санхүүжилт, зохион байгуулалтын асуудлуудыг гишүүдийн хурлаар бие даан шийдвэрлэх (Хуулийн 26.3) эрхтэй бөгөөд үйл ажиллагааны тайлангаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлэх үүрэгтэй (Хуулийн 26.4).

Ийнхүү АЖМХ нь Аялал жуулчлалын тухай хуулиар тодорхойлсон эрх, үүргүүдийг хэрэгжүүлэх замаар Монгол Улсын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, чанаржуулах, тогтвортой байдлыг хангах чухал гүүр болж ажилладаг хууль ёсны субъект юм.

3. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Энэхүү стратегийн зорилго нь Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоог **хууль ёсны, хүчирхэг бүтэцтэй, үр дүнтэй менежменттэй, санхүүгийн хувьд бие даасан тогтвортой байгууллага болгон төлөвшүүлэх явдал юм.** Үүгээр дамжуулан Монгол Улсын аялал жуулчлалын салбарыг олон улсад өрсөлдөх чадвартай, эдийн засгийн өндөр үр ашигтай, байгальд ээлтэй, тогтвортой салбар болгож, улмаар жуулчдын тоог тогтвортой нэмэгдүүлэн, Монголын онцлог бүхий үндэсний брэндийг дэлхийд таниулах, салбарын менежмент, хүний нөөцийн чадавхийг олон улсын түвшинд хүргэж, аялал жуулчлалын үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэхэд оршино.

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны **урт хугацааны стратегийн зорилгууд** нь Холбооны санаачилсан үзэл баримтлал, бодлогын санаачлага, төрийн дэмжлэг, олон улсын хамтын ажиллагаа, салбарын бүх оролцогчдын оролцоотойгоор хэрэгжүүлэх стратегийн луужин байх юм.

1. **Брэнд ба Бүтээгдэхүүн:** Монголын аялал жуулчлалын ондоошилтой брэнд, дөрвөн улирлын аялал жуулчлал ба тогтвортой хөгжлийн үзэл санааг тодорхойлох, хөгжүүлэх, сурталчлах – *Зах Зээл, Маркетингийн ЧҮХ, Эвент Хамтын Ажиллагааны ЧҮХ*
2. **Бүсчилсэн хөгжил:** Аялал жуулчлалын бүсчилсэн хөгжлийг дэмжиж, бүсүүдэд аялал жуулчлалын мастер төлөвлөлт хийх, дэд бүтцийн уялдааг хангах – *Дэд Бүтэц, Цахим Шилжилтийн ЧҮХ*
3. **Стандарт ба Чанар:** Олон улсын стандарт нэвтрүүлж, хяналтын тогтолцоо үүсгэж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэн, чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах – *Хууль Зүй, Стандарт, Хөрөнгө Оруулалтын ЧҮХ*
4. **Судалгаа ба Хүний нөөц:** Иж бүрэн судалгаанд суурилан бодлогын зөвлөмж боловсруулж, салбарын хүний нөөцийг олон улсын түвшинд чадавхжуулах, гэрчилгээжүүлэх – *Судалгаа, Хүний Нөөцийн ЧҮХ*
5. **Засаглал:** Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн статусыг бэхжүүлж, олон улсын ба орон нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн тэлж, холбооны менежмент, санхүүгийн бие даасан байдлыг ханган гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх – *(Удирдах Зөвлөл /Ажлын алба)*

Зах зээл, Маркетингийн ЧҮХ, Эвент ба Хамтын Ажиллагааны ЧҮХ

1. Брэнд ба бүтээгдэхүүн:

- 1.1. "Монгол хүнээр дамжин илрэх үнэ цэнтэй аяллын брэнд" бий болгох. Энэ брэндийн үзэл баримтлал нь "Монголын байгаль, соёлын өв нөөц Монгол хүний сэтгэлгээгээр дамжин амилдаг" гэсэн санаан дээр тулгуурлана. Энэ үзэл баримтлалыг хэрэгжүүлэх арга замууд нь:

Эхний үе шат: "Үйлчилгээний ажилтан" бүр "Соёлын Элч" болох сэтгэлгээний өөрчлөлт хийх нь:

- "Зочломтгой Монголчууд – Mongolian Hospitality" стандартыг кодчилох: Үйлчилгээний техникт Монгол хүний зочломтгой зан, нүүдэлчин ахуйн халуун дулаан харилцааг шингээсэн харилцааны кодыг (Code of Conduct) бий болгох.
- "Амьд түүхийг өгүүлэгч нар – Storytellers": Хөтөч, жолооч, орон нутгийн иргэд, аялал жуулчлалын бүтээгдэхүүн бүрт оролцогчдыг "амьд түүх" ярих, сэтгэл хөдлөл дамжуулагч болгон бэлтгэх.
- Брэндийн нүүр царайг тодруул: "Go Mongolia" брэндийн нүүр царайг зөвхөн байгалийн зургаар биш, бодит хүмүүсээр төлөөлүүлэн гаргаж ирэх.

Хоёрдугаар үе шат: Чадавхжуулалт ба "Зөөлөн ур чадварын" хувьсгал

- Сэтгэл хөдлөлийн оюун ухааны сургалт: Жуулчны сэтгэл зүйг мэдрэх, соёл хоорондын ялгааг хүндэтгэх, зөрчлийг эерэгээр шийдвэрлэх "Soft Skills" сургалтыг бүх шатанд нэвтрүүлэх.
- Мэргэшсэн "Мастер" түвшин: Хөтөч, үйлчилгээний ажилтнуудыг зөвхөн хэлний мэдлэгээр бус, төрөлжсөн сэдвээр амьд түүх өгүүлэх (шувуу судлал, палеонтологи, буддизм г.м) мэргэшүүлж, "Expert Guide" зэрэглэлтэй болгох.
- Менторшип хөтөлбөр: Туршлагатай "Соёлын элч"-үүд шинэ залуу үеийнхэндээ үнэт зүйлээ өвлүүлэх тогтолцоог бүрдүүлэх.

Гуравдугаар үе шат: Бүтээгдэхүүн дэх "Хүний оролцоо"-г дизайчилж өгөх буюу аяллын хөтөлбөр бүрт "Хүнтэй харилцах" үнэ цэнийг шингээх.

- "Meet the Local" хөтөлбөрүүд: Аяллын маршрутад зүгээр нэг малчин айлд очих бус, тухайн айлын гишүүнтэй хамт ажил хийх, ярилцах, суралцах цагийг тусгайлан төлөвлөх,
- Хөтөч төвтэй аяллууд: Аяллын маршрутыг газраар нь бус, тухайн аяллыг удирдаж буй хөтчийн нэр хүнд, ур чадвар дээр суурилан зарлах (Жишээ нь: "Баяраатай хамт Алтайн уулсыг тольдох нь").

- Орон нутгийн иргэдийн оролцоо: Нутгийн иргэдийг зөвхөн үйлчилгээ үзүүлэгч биш, аяллын туршлагыг хамтран бүтээгч (co-creator) болгох сургалт явуулах.

Дөрөвдүгээр үе шат: Үнэлгээ ба Урамшууллын "Од" систем - *Хүний үнэ цэнийг бодитоор үнэлж, алдаршуулах.*

- "People's Choice" үнэлгээний систем: Жуулчдын сэтгэл ханамжийн үнэлгээг зөвхөн байгууллагад бус, үйлчилгээ үзүүлсэн хувь хүнд (хөтөч, жолооч) өгдөг цахим системийг "Go Mongolia" платформ дээр хөгжүүлэх.
- "Монголын Аялал Жуулчлалын Одууд" шагнал: Шилдэг үйлчилгээ үзүүлэгчдийг жил бүр шалгаруулж, мөнгөн шагналаас гадна олон улсад суралцах эрхээр шагнах, тэднийг салбарын "Баатар" болгох.
- Карьерын өсөлтийн шатлал: Сайн ажиллаж буй хүмүүсийн зэрэглэлийг ахиулж, тэр хэрээр цалин хөлс, үнэлэмж нь өсдөг шударга системийг хэвшүүлэх.

Тавдугаар үе шат: Маркетинг - "Монголын Байгалийн Өв- Хүнэчилж, амьдруулах", "Монголын Түүх – Монгол Хүнээр" гэх мэт *Маркетингийн агуулгад байгалиас илүү "Хүн"-ийг тодотгох.*

- "Faces of Mongolia" кампанит ажил: Олон улсын сурталчилгаанд байгалийн зургаас гадна инээмсэглэж буй малчин, чадварлаг хөтөч, авъяаслаг тогоочийн түүхийг, яриаг (vlog) түлхүү ашиглах.
- Хөтөч-Инфлүэнсер: Хөтөч нарыг өөрсдийн сошиал сувгаар дамжуулан Монголыг сурталчлах контент бүтээгч болоход нь дэмжлэг үзүүлэх.
- Бодит түүхүүд (Testimonials): Жуулчдын сэтгэгдлийг хуваалцахдаа "Сайхан газар байлаа" гэхээсээ илүү "Тэр хүн надад ийм сэтгэгдэл төрүүллээ" гэсэн агуулгуудыг онцолж түгээх.

1.2. Брэндинг ба Олон улсын сурталчилгаа - "Go Mongolia" брэндийг "Хүн төв"-тэйгээр олон улсын зорилтот зах зээлд хоногшуулж, Монгол Улсыг аялал жуулчлалын тэргүүлэх чиглэл болгох.

1.2.1. National Geographic, CNN Travel, Lonely Planet зэрэг дэлхийн томоохон платформ, сувгуудтай хамтран контент бүтээж, түгээнэ.

1.2.2. Олон улсын нөлөө бүхий блогер, инфлүэнсер, сэтгүүлчдийг урьж "Press Trip" зохион байгуулан, бодит аяллын туршлагыг сурталчилна.

1.2.3. ITB Berlin, WTM London, SITF, JATA, COTM, ITB ASIA, USTOA CONVENTION гэх мэт дэлхийн ТОП үзэсгэлэнгүүдэд Монголын павильоныг "Хүн төв"-тэй өнгө төрхтэйгээр, тогтмол, чанартай оролцуулна.

1.2.4. "Go Mongolia" рүүд шоу – Монгол хүмүүстэй танилц" зохион байгуулж, шууд хэрэглэгчдэд хүрнэ.

- 1.2.5. "Go Mongolia" нэгдсэн вэбсайт болон аппликейшнийг 5 хэл дээр (Англи, Хятад, Япон, Солонгос, Герман) хөгжүүлж, мэдээлэл болон захиалгын нэгдсэн системтэй болгоно .
- 1.2.6. Booking.com, Expedia, TripAdvisor зэрэг дэлхийн томоохон OTA (Online Travel Agency) платформд Монголын зочид буудал, тур операторуудын бүтээгдэхүүнийг бүртгүүлж, борлуулалтын сувгийг нээнэ .
- 1.3. Бүтээгдэхүүн хөгжүүлэлт ба Улирлын хамаарлыг бууруулах: Өвөл, хавар, намрын жуулчлалыг хөгжүүлэх:
 - 1.3.1. "Nomadic Winter Festival" буюу "Монголын Өвөлд Таныг Угтах Нүүдэлчид" (Мөсөн хотхон, морин чарга, мөсөн урлал) олон улсын брэнд эвент болгон хөгжүүлнэ .
 - 1.3.2. Мөсөн дээрх загасчлал, нохой чарга, цасны гуталтай алхалт зэрэг өвлийн ниш (niche) бүтээгдэхүүнүүдийг стандартжуулан санал болгоно .
 - 1.3.3. Мал төллөх үеийн "Төлийн баяр"-ыг нүүдэлчдийн ахуйтай танилцах эвент болгон хөгжүүлнэ.
 - 1.3.4. "Говь Фестиваль" – Gobi Artists, "Монгол Морьтон Фестиваль" (Mongolian Cowboy Adventure), "Монголын Адал Явдлын Фестиваль" (Mongolian Extreme Sport Activits) зэрэг олон улсын жуулчдыг татах томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулна.
 - 1.3.5. Нүүдэлчдийн амьдралыг харуулсан интерактив "Nomadic Village" соёлын парк байгуулна.
 - 1.3.6. Үлэг гүрвэлийн олдвор бүхий газруудад (Өмнөговь г.м) "Үлэг гүрвэлийн парк", виртуал театр байгуулж, палеонтологийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ .
 - 1.3.7. "Mongolia Tourism Week" болон олон улсын хөрөнгө оруулалтын форумыг тогтмолжуулж, бизнес уулзалт, хурал, үзэсгэлэнгийн аялал жуулчлалыг дэмжинэ .
 - 1.3.8. Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх ажилд манлайлан оролцоно.
- 1.4. Дотоодын аялал жуулчлал
 - 1.4.1. "Эх орноороо аялцгаа" үндэсний аян болон "Миний эх орон – Миний аялал" контентын уралдаан зохион байгуулна .
 - 1.4.2. Үндэсний телевизүүдтэй хамтран дотоодын аяллын цуврал нэвтрүүлэг бэлтгэнэ.
 - 1.4.3. "21 аймгийн аялал", "Түүхэн аялал", "Байгалийн гайхамшиг" зэрэг сэдэвчилсэн маршрутуудыг хөгжүүлнэ.
 - 1.4.4. "Аяллын оноо" хуримтлуулах систем болон орон нутгийн иргэдэд зориулсан хөнгөлөлтийн систем нэвтрүүлнэ .

Дэд Бүтэц, Цахим Шилжилтийн ЧҮХ

2. Бүсчилсэн хөгжил ба дэд бүтэц: Аялал жуулчлалын бүсүүдийг харилцан уялдаатай хөгжүүлж, олон улсын стандартад нийцүүлэх.
 - 2.1. Газар ашиглалт ба Мастер төлөвлөгөө: Аялал жуулчлалын бүсүүдэд газар ашиглалтын болон бүсчилсэн мастер төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхийг дэмжинэ. "21 аймгийн аялал" болон бүсчилсэн томоохон маршрутуудыг (Төв, Баруун, Говь, Хангай) хөгжүүлж, аймаг бүрийн онцлог бүтээгдэхүүнийг, түүнд оролцогч "Монгол хүн"-ийг тодорхойлно .
 - 2.2. Тэмдэг тэмдэглэгээний стандартчилал: Монгол Улсын бүх засаг захиргааны нэгж, газар орны нэр, орчуулагдахгүй нэр томъёоны латин бичлэгийг стандартжуулах ажлыг хийж, жуулчдыг төөрөгдлөөс сэргийлнэ.
 - 2.3. Бүс хоорондын хамтын ажиллагаа: Аймаг, бүс нутгуудын хооронд тогтмол форум, туршлага солилцох уулзалт зохион байгуулж, нөөцийг оновчтой хуваарилна.
 - 2.4. Туршилтын хөтөлбөр: МТО-ийн салбаргүй бүсүүдэд хөгжлийн баг томилон туршилтын (pilot) төслүүд хэрэгжүүлж, хамтын ажиллагааг эхлүүлнэ.
 - 2.5. Хатуу дэд бүтэц
 - 2.5.1. Агаарын тээвэр: Агаарын тээврийн либералчлалыг дэмжиж, олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ. Дотоодын нислэгийн хуваарийг тогтмолжуулж, эвентэд зориулсан нислэгийг 1-2 жилийн өмнө урьдчилан төлөвлөх боломжтой болгоно. Нислэгийн компаниудтай мэдээлэл солилцох систем, шууд харилцааны сүлжээ байгуулна.
 - 2.5.2. Төмөр зам: "Транс-Монголын төмөр зам"-ын брэндийг хөгжүүлж, жуулчны бүсүүдийг холбосон тусгай маршрутуудыг тодорхойлно. Вокзал болон галт тэрэгний үйлчилгээ, ая тухыг сайжруулах санал гаргана.
 - 2.5.3. Авто зам: Жолооч нарын санал хүсэлтийг авах дижитал хэрэгсэл (feedback tool) хөгжүүлж, тэмдэглэгээгүй хэсэг, үйлчилгээ дутмаг цэгүүдийг илрүүлэн сайжруулна.
 - 2.5.4. Нийтийн тээвэр: Нийтийн тээврийн төлбөр, онлайн захиалгын системийг англи хэл дээр ашиглах боломжийг дэмжинэ.
- 2.6. Үйлчилгээний дэд бүтэц ба Байр сууц
 - 2.6.1. Жуулчны бааз, амралтын газруудын шинэчлэл, засварт хөнгөлөлттэй зээл, татварын урамшуулал авах бодлогыг дэмжинэ.
 - 2.6.2. Тогтвортой архитектур, ногоон шийдлийг дэмжиж, санхүүжилтийн боломжийг нээж өгнө.
 - 2.6.3. Гишүүн байгууллагуудын эрхийг хамгаалж, хууль бус дарамт, хүнд сурталтай холбоотой гомдлыг шийдвэрлэхэд хууль зүйн дэмжлэг үзүүлнэ.
 - 2.6.4. Орон нутгийн иргэдийг гэр буудал, homestay үйлчилгээ эрхлэхэд чиглэсэн сургалт, гарын авлагаар хангаж, стандартыг нутагшуулна.

- 2.6.5. Улирлын хамаарлыг бууруулах зорилгоор соёлын тоглолт, галерей, театр, энтертайнмент төвүүдэд хөрөнгө оруулалт татах бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 2.7. Отоглох цэг ба Ариун цэвэр: Хариуцлагатай кемпингийн соёлыг түгээж, ариун цэврийн байгууламж бүхий албан ёсны кемпийн цэгүүд байгуулахыг дэмжинэ.
- 2.8. Хил, Гааль: Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, зорчигчийн тав тухыг хангах талаар бодлогын санал гаргана.
- 2.9. Цахим дэд бүтэц (Digital Infrastructure)
- 2.9.1. "Go Mongolia" аялал жуулчлалын нэгдсэн дижитал платформ хөгжүүлж, захиалга, мэдээлэл, төлбөр тооцооны системийг нэгтгэнэ.
- 2.9.2. Монголын аялал жуулчлалын бүх бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн цахим сан (Database) байгуулна.
- 2.9.3. Дижитал орчин дахь хандалт, оролцоог хэмжих аналитик систем нэвтрүүлж, шийдвэр гаргалтад ашиглана.

Хууль эрхзүй, Стандарт, Хөрөнгө Оруулалтын ЧҮХ

3. Стандарт ба Чанар:

3.1. Байр сууц, Үйлчилгээний байгууллагын стандарт (Бүрэн хувилбар)

3.1.1. Ангилал, зэрэглэлийн шинэчлэл:Зочид буудал, жуулчны бааз, амралтын газруудыг 1-5 одтой зэрэглэлээр ангилах системийг шинэчилж, ISO болон UNWTO-ны жишигт нийцүүлнэ .

3.1.2. Аялал жуулчлалын тухай хуулийн 6.5-д заасны дагуу ангилал, зэрэглэл тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох ажлыг даан зохион байгуулна.

3.1.3. Ногоон болон Чанарын гэрчилгээ:"Green Globe Certification" стандартыг нэвтрүүлж, байгальд ээлтэй байгууллагуудад "Mongolian Green Tourism Certification" олгоно .

3.2. Мэргэжлийн үйлчилгээний стандарт

3.2.1. Жуулчны хөтөч-тайлбарлагчийн зэрэглэл: Жуулчны хөтөч тайлбарлагид хамаарах журамд шинэчлэл хийж, “Хүн төв”-тэй аялал жуулчлалын брэндэд нийцүүлэн зэрэглэл тогтоох системийг бий болгоно.

3.2.2. Аялал жуулчлалын тухай хуулийн 10.1-д заасны дагуу хөтөч-тайлбарлагчийн үнэмлэх олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох ажлыг гүйцэтгэнэ.

3.2.3. Тур оператор, Агентын ангилал: Тур оператор болон аяллын агентуудыг үйл ажиллагааны чиглэлээр нь (Инбаунд, Аутбаунд, Дотоодын) ялгаж ангилан, стандарт тогтооно .

3.3. Хууль эрх зүйн орчин ба Хөрөнгө оруулалт

3.3.1. Татвар ба Хөдөлмөрийн бодлого: Аялал жуулчлалын салбарт гадаад улсаас ажиллах хүч авахад татвар, хураамжийн хөнгөлөлт үзүүлэх санал боловсруулж дэмжүүлнэ.

3.3.2. Зочид буудал, цогцолборын шинэчлэл, засварт хөнгөлөлттэй зээл, татварын урамшуулал авах бодлогыг дэмжинэ.

3.3.3. Аялал жуулчлалын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийж, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийн саналыг боловсруулна .

3.4. Аюулгүй байдал ба Хяналтын систем

3.4.1. Аюулгүй байдлын стандарт: Хээрийн болон адал явдалт аяллын (Adventure Travel Safety Standard) олон улсын аюулгүй байдлын стандартыг нэвтрүүлэн, мөрдүүлнэ.

3.5. Хяналт ба Эргэх холбоо:

3.5.1. Жуулчдын санал, гомдол, үнэлгээг авах цахим платформ хөгжүүлж, үйлчилгээний чанарт байнгын аудит хийх тогтолцоог бүрдүүлнэ .

3.5.2. Аялал жуулчлалын тухай хуулийн 6.4-т заасны дагуу тур оператор, агентуудын бүртгэлийг хөтөлж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.

Сургалт, Судалгаа, Хүний Нөөцийн ЧҮХ

4. Судалгаа ба Хүний Нөөц

4.1. Иж бүрэн Судалгаа ба Мэдээллийн сан

- 4.1.1. Аялал жуулчлалын салбарын өнөөгийн болон ирээдүйн ажлын байр тус бүрт шаардлагатай ур чадвар, мэдлэг, чадамжийг тодорхойлох үнэлгээ хийнэ.
- 4.1.2. Одоогийн ажиллах хүчний ур чадварыг шаардлагатай түвшинтэй харьцуулж, ур чадварын зөрүүгийн (skills gap) шинжилгээ хийнэ.
- 4.1.3. Монгол Улсын байгаль, соёлын үнэт өв, гол зах зээлүүд, жуулчдын сэтгэл ханамжийг хамарсан иж бүрэн судалгаа хийнэ.
- 4.1.4. Одоогийн судалгаа, ишлэл, дүгнэлтийг нэгтгэсэн мэдээллийн нөөц бүрдүүлж, гишүүдэд ашиглах боломжийг олгоно.

4.2. Мэргэшүүлэх Сургалт ба Боловсрол

4.2.1. Ажлын байрны тусгайлсан сургалтууд (SOP):

Дараах чиглэлүүдээр стандарт ажиллагааны журам (SOP) болон мэргэжлийн сургалтуудыг зохион байгуулна:

- Жуулчны хөтөч-тайлбарлагч.
- Жуулчны тээврийн жолооч.
- Аялал жуулчлалын агент ба менежерүүд .
- Аяллын ахлагч
- Зочид буудал, баазын менежер, үйлчлэгч, ресепшн, гал тогооны ажилтнууд г.х

4.2.2. Менторшип хөтөлбөр: Туршлагатай мэргэжилтнүүд шинэ ажилтнуудад чиглүүлэх, хөгжүүлэх дэмжлэг үзүүлэх "Менторшип" тогтолцоог нэвтрүүлнэ.

4.2.3. Боловсролын байгууллагын хамтын ажиллагаа:

- 4.2.3.1. Их, дээд сургууль, МСҮТ-үүдтэй хамтран салбарын хэрэгцээнд нийцсэн сургалтын хөтөлбөр боловсруулна.
- 4.2.3.2. Олон улсын аялал жуулчлалын сургалтын тэтгэлэг, солилцооны хөтөлбөрүүдийг бий болгоно.

4.3. Гэрчилгээжүүлэлт ба Олон улсын стандарт

- 4.3.1.1. Жуулчны хөтөч нарт WFTGA (Дэлхийн хөтөч нарын холбоо)-ны итгэмжлэгдсэн сургалтыг заах олон улсын сургагч багш нарыг бэлдэнэ.
- 4.3.1.2. Менежерүүдэд зориулсан "Hospitality Management", "Sustainable Tourism Management" зэрэг олон улсын сургалтуудыг нэвтрүүлнэ.

4.4. Хүний нөөцийн бодлого ба Хангамж

- 4.4.1.1. Карьер сурталчлах: Аялал жуулчлалыг ирээдүйтэй, үнэ цэнтэй салбар гэж таниулан, ажил мэргэжлийн боломжуудыг сурталчилж шинэ боловсон хүчин татна.

- 4.4.1.2. Гадаад ажиллах хүчний бодлого: Аялал жуулчлалын салбарт гадаад улсаас ажиллах хүч ажиллуулахад татвар хураамжийн хөнгөлөлт үзүүлэх санал боловсруулж дэмжүүлнэ.
 - 4.4.1.3. Санхүүжилт татах: Аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх чиглэлд олон улсын байгууллагуудаас тусгай санхүүжилт татахыг зорино.
 - 4.4.1.4. Урамшууллын систем: Салбарын шилдэг ажилтнуудын ур чадварыг хүлээн зөвшөөрч, шагнал урамшуулал олгох тогтолцоог бий болгоно.
- 4.5. Хяналт-шинжилгээ
- 4.5.1.1. Үнэлгээний систем: Хүний нөөцийн хөгжлийн стратеги, сургалтын үр дүнг үнэлэх хяналтын систем нэвтрүүлж, үр дүнг тооцно.

Удирдах Зөвлөл, Ажлын Алба

5. Засаглал: Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн статусыг бэхжүүлж, олон улсын ба орон нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн тэлж, холбооны менежмент, санхүүгийн бие даасан байдлыг ханган гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх – (Холбооны Удирдах Зөвлөл/ Ажлын алба)
 - 5.1. Удирдах зөвлөл ба Чиг Үүргийн Хороодын бүтэц: Удирдах зөвлөл, Чиг үүргийн хороодын үүрэг, хариуцлага, тайлагналын бүтцийг нарийвчлан тодорхойлно. Шийдвэр гаргах үйл явц дахь мэдээллийн урсгалын зураглал (System map)-ыг гаргаж, хурлын хуваарийг тогтмолжуулна.
 - 5.2. Иж бүрэн менежментийн системийг (хүний нөөц, санхүү, үйл ажиллагаа, харилцаа холбоо, маркетинг, дотоод хяналт) хэрэгжүүлж, SOP (Стандарт үйл ажиллагааны журам)-ыг нарийвчлан гаргах, арга хэмжээ, сургалт, форум зохион байгуулах нарийвчилсан зааварчилгаа (Manual)-г боловсруулж, ложистик төлөвлөлтийг стандартжуулна. Төслийн санал боловсруулах, тайлан гаргах, хууль бодлогын санал оруулах нэгдсэн загвар (template)-уудыг ашиглаж хэвшүүлнэ. Ажлын албаны албан тушаал бүрийн тодорхойлолт, гүйцэтгэлийн үнэлгээ (KPI), карьерын өсөлтийн төлөвлөгөөг баталж мөрдүүлнэ. Эрсдэлийн үнэлгээг ашиглан байгууллагын тогтвортой, үр дүнтэй удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх.
 - 5.3. Санхүүгийн бие даасан хөгжлийг дэмжих: Олон улсын төсөл, гишүүнчлэлийн татвар, сургалт, зөвлөх үйлчилгээ, бүтээгдэхүүн борлуулалт, цахим хандив зэрэг орлогын олон эх үүсвэрийг бүрдүүлж, төслийн санал боловсруулах загвар ашиглан санхүүжилт татах замаар санхүүгийн бие даасан байдал, ил тод байдлыг хангах.
 - 5.4. Холбооны хүрээг өргөтгөх ба гишүүдэд өгөх үнэ цэнийг нэмэгдүүлэх:
 - 5.4.1. Орон нутгийн салбар холбоодыг байгуулж, гишүүнчлэлийг өргөтгөх.
 - 5.4.2. Гишүүдэд мэргэжлийн хөгжил, бодлогод нөлөөлөх боломж, мэдээлэл, туршлага, нетворк, эрх ашгийг хамгаалах бодит үнэ цэн бүхий үйлчилгээ үзүүлэх замаар Холбооны хүрээг өргөжүүлэн, оролцоог нэмэгдүүлэх.
 - 5.4.3. Хөнгөлөлт ба Урамшуулал: Гишүүдэд зориулсан хөнгөлөлт, давуу талын жагсаалт гаргах, санхүүгийн боломжуудыг (зээл, татварын хөнгөлөлт) зуучлах.
 - 5.4.4. Хувь хүний хөгжил: Гишүүдэд зөвхөн мэргэжлийн бус "Зөөлөн ур чадвар" (Soft skills), шинэ хобби, сонирхлоо нээх боломжийг олгох.
 - 5.4.5. Борлуулалтын суваг: Гишүүдийн бүтээгдэхүүнийг борлуулах "Бараа борлуулалтын сувгийн тодорхойлолох"
 - 5.5. Удирдах зөвлөлийн гишүүд нь өөрсдийг нь сонгосон салбар холбоодыг хэрхэн манлайлал үзүүлэхийг тодорхойлно. Салбар холбоодтой хамтарсан сургалт, семинар, вебинарын төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжүүлнэ.
 - 5.6. Цахим шилжилт ба мэдээллийн хүртээмжийг сайжруулах: Олон нийтэд хүртээмжтэй мэдээллийн төв вэбсайт, сошиал сувгуудыг хөгжүүлж, цахим орчныг шинэ түвшинд гаргах. Технологи, онлайн платформыг ашиглан борлуулалт,

маркетинг, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх замаар цахим шилжилт, мэдээллийн хүртээмжийг сайжруулах.

- 5.7. Хуулиар хүлээсэн төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх: Аялал жуулчлалын тухай хуулийн дагуу тур оператор, зочид буудал, аялал жуулчлалын цогцолбор, жуулчны баазууд гэх мэт байршуулах хэрэгслүүд, аяллын агент, жуулчны хөтөч-тайлбарлагчийн бүртгэл, ангилал, зэрэглэл тогтоох, үнэмлэх олгох ажлыг хэрэгжүүлэх. Маргаан шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлах мэргэжлийн бүтцийг ажиллуулж, хуулиар хүлээсэн төрийн чиг үүргээ бүрэн гүйцэтгэх.

ХАВСРАЛТ 1

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ САЛБАР ХОЛБООНД ҮЗҮҮЛЭХ МАНЛАЙЛАЛ

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНИЙ МАНЛАЙЛЛЫН ЗУРАГЛАЛ

Манлайллын Үндсэн Үүрэг: УЗ-ийн гишүүн нь Дээвэр Холбоо ба Салбар Холбооны хоорондох **"Амьд гүүр"** болж, салбарын эрх ашгийг дээд түвшинд хамгаалахын сацуу төвөөс гарсан бодлогыг салбарт нутагшуулах үүрэг хүлээнэ.

1. МАНЛАЙЛЛЫН 4 ТУЛГУУР ЧИГЛЭЛ

УЗ-ийн гишүүн нь хариуцсан (эсвэл сонгогдсон) Салбар холбоондоо дараах 4 чиглэлээр манлайлал үзүүлнэ:

№	Чиглэл	Манлайллын хэлбэр	Хэрхэн хэрэгжүүлэх вэ? (Үйлдэл)
1	Бодлогын Гүүр (Representation)	"Доороос дээш" Дуу хоолой болох	- Салбар холбооны тулгамдсан асуудал (Татвар, зөвшөөрөл, дэд бүтэц)-ыг УЗ-ийн хуралд албан ёсоор оруулж шийдвэрлүүлэх. - Салбар холбооны санал санаачилгыг стратегийн баримт бичигт тусгуулах.
2	Стратегийн Чиглүүлэгч (Strategic Guide)	"Дээрээс доош" Бодлого нутагшуулагч	- АЖМХ-ны 2025-2030 оны стратегийг Салбар холбооны жилийн төлөвлөгөөтэй уялдуулахад зөвлөх. "Go Mongolia" брэндийн үнэ цэнийг салбарын гишүүдэд ойлгуулах, нэгдмэл байдлыг хангах.
3	Нөөцийн Холбогч (Resource Connector)	"Гаднаас дотогш" Боломж нээгч	- Салбар холбоонд хэрэгцээтэй олон улсын төсөл, санхүүжилт, хөрөнгө оруулагчтай холбож өгөх. - Төрийн байгууллага, яамтай харилцахад нь "Дээвэр" болж, улс төрийн болон албан ёсны дэмжлэг үзүүлэх.
4	Үнэт зүйлийн Хамгаалагч (Guardian of Values)	"Дотооддоо" Соёл түгээгч	- Салбар холбооны дотоод засаглал, ёс зүй, ил тод байдлыг хянах, зөв жишиг тогтоох. "Хүн төвтэй" үзэл санааг гишүүдэд үлгэрлэх.

2. ХАРИЛЦААНЫ ЦИКЛ (Interaction Cycle)

УЗ-ийн гишүүн Салбар холбоотойгоо хэрхэн, ямар давтамжтай ажиллах зураглал:

- **Жилийн эхэнд (Төлөвлөлт):**
 - Салбар холбооны "Жилийн нэгдсэн хурал"-д биечлэн оролцоно.
 - Салбарын тэргүүнтэй уулзаж, жилийн KPI болон Төв холбооноос авах дэмжлэгийг тохирно.
- **Улирал тутам (Хяналт & Дэмжлэг):**

- Салбар холбооны удирдах багтай цахим/танхим уулзалт хийж, ажлын явцтай танилцана.
- Тулгамдаж буй асуудлыг сонсож, дараагийн УЗ-ийн хурлын хэлэлцэх асуудалд оруулна.
- **Жилийн дундуур (Төсөл & Арга хэмжээ):**
 - Салбар холбооноос зохион байгуулж буй томоохон эвент, сургалтад "Хүндэт зочин"-оор оролцож, салбарын нэр хүндийг өсгөнө.
 - Төв холбооны Чиг үүргийн хороодтой салбарыг холбох ажлыг зохион байгуулна.
- **Жилийн эцэст (Үнэлгээ):**
 - Салбар холбооны тайланг хэлэлцэхэд оролцоно.
 - Шилдэг гишүүдийг шагнуулах, урамшуулах асуудлыг Төв холбоонд уламжилна.

3. ЭРХ МЭДЭЛ БА ХЯЗГААРЛАЛТ

Манлайлал нь "Өмнүүр нь орж хийх" биш "Дэмжих" байх ёстойг тодорхойлох нь чухал.

- **Хийх зүйл:**
 - Стратегийн чиглэл өгөх.
 - Ментор хийх, зөвлөх.
 - Төв холбоонд лобби хийх.
 - Хямралын үед хамгаалах.
- **Хийхгүй зүйл:**
 - Салбар холбооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах (Микро менежмент).
 - Салбарын санхүүг дур мэдэн захиран зарцуулах.
 - Гүйцэтгэх захирлын эрх мэдэлд халдах.

4. МАНЛАЙЛЛЫН ҮР ДҮНГ ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТ (KPI for Board Member)

УЗ-ийн гишүүнийг Салбар холбоонд хэр сайн манлайлал үзүүлснийг дараах байдлаар үнэлнэ:

1. **Бодлогын тусгал:** Салбар холбооноос гарсан хэдэн санал Төв холбооны шийдвэрт туссан бэ?
2. **Нөөц бүрдүүлэлт:** Салбар холбоонд хэдэн төгрөгийн төсөл, эсвэл хэдэн түншлэлийг зуучилсан бэ?
3. **Гишүүнчлэлийн өсөлт:** Хариуцсан салбар холбооны гишүүдийн тоо болон сэтгэл ханамж өссөн үү?
4. **Идэвх:** Салбар холбооны хурал, арга хэмжээнд оролцсон ирц.

ХАВСРАЛТ 2

ЧИГ ҮҮРГИЙН ХОРООДЫН АЖЛЫН УЯЛДАА ХОЛБОО

АЖМХ-ны Чиг Үүргийн Хороод (ЧҮХ) нь тус тусдаа бие даасан нэгжүүд мэт боловч, стратегийн ерөнхий зорилгод хүрэхийн тулд **"Цагны араа"** шиг нэг нь нөгөөгөө хөдөлгөж, харилцан хамааралтай ажиллах шаардлагатай.

1. ЗОХИЦУУЛАЛТЫН МЕХАНИЗМ: "ГҮҮР" БҮТЭЦ

Хороод хоорондын уялдааг хангахын тулд дараах 3 түвшний холбоосыг бий болгоно:

А. Стратегийн түвшинд: "Дэд Ерөнхийлөгч Нарын Зөвлөл"

- **Бүрэлдэхүүн:** 5 ЧҮХ-ны дарга + Гүйцэтгэх захирал (Ажлын алба).
- **Давтамж:** Улиралд 1 удаа.
- **Үүрэг:** Нэг хорооны хийж буй ажил нөгөө хорооны төлөвлөгөөтэй зөрчилдөхгүй байх, нөөцийг давхардуулахгүй байхыг хянаана.

Б. Гүйцэтгэлийн түвшинд: "Төслийн дундын баг" (Task Forces)

- Томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхэд ганц хороо хүчрэхгүй тул **"Дундын ажлын хэсэг"** байгуулна.
- **Жишээ нь:** "Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх" төсөл дээр:
 - **Маркетингийн хороо:** Сурталчилгааг хийнэ.
 - **Стандартын хороо:** Мөсөн дээрх аюулгүй байдлыг хангана.
 - **Хүний нөөцийн хороо:** Өвлийн хөтөч нарыг сургана.

В. Өдөр тутмын түвшинд: "Ажлын алба - Мэдээллийн зангилаа"

- АЖМХ-ны Ажлын алба нь хороод хоорондын мэдээллийн урсгалыг зохицуулах гол зангилаа байна.
- Хороо бүрийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг бусад хороодод нээлттэй байлгах үүргийг Ажлын алба хүлээнэ.

2. ХОРООД ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ МАТРИЦ

Аль хороо нөгөө хороотойгоо ямар асуудал дээр огтлолцохыг дараах хүснэгтээр харуулж байна:

ЧИГ ХОРОО	ҮҮРГИЙН ХАМТРАН АЖИЛЛАХ ХОРОО	УЯЛДАА ХОЛБОО, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЦЭГ
